

Батлав.  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧИЙН АЛБАН-ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *В.М.* Ц.НАРАНЧИМЭГ

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, ҮРДҮНД ХИЙЖ БУЙ АУДИТАД  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 7 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар .....  
*ЧАГ-Аж*  
*2021-26(02)*

Улаанбаатар хот

### АЖЛЫН ЗОРИЛГО

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн сэдвээр хийж буй гүйцэтгэлийн аудитаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд оролцогч буюу хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч, захиалагчийн гэрээний хэрэгжилт, талуудын төсөлд зарцуулсан хөрөнгө, тэдгээрийн зарцуулалт, үр нөлөөг нягтлан шалгаж, төслийг хэрэгжүүлсэн эрх зүйн орчин, ажил гүйцэтгэх болон санхүүжүүлэх гэрээ, бусад дагалдан гарсан шийдвэр, гэрээ, хэлцэл, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг судлан Монгол Улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичигт нийцэж буй эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилт оршино.

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Шинжээч нь аудитын тайлагналын үе шатанд ажлын даалгаварт тусгасан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

**Эхлэх хугацаа:** 2023 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

**Дуусах хугацаа:** 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2021 оны 06, 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Үндэсний аудитын газрын 2022-2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу тавигдах шаардлагад заасан чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийн бүрэлдэхүүнийг тухайн аудитад татан оролцуулна.

### ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө оруулат, санхүүжилт, зарцуулалттай холбоотой Талуудын

хооронд байгуулсан гэрээ, хэлцэл, шийдвэрүүд, анхан шатны баримтууд болон холбогдох бусад материалыг хамруулан хууль, эрх зүйн байдалд хараат бус, мэргэжлийн дүгнэлт гаргана.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажилбаруудыг хэрэгжүүлж, аудитын талбарын болон тайлагналын үе шатны үйл ажиллагаанд шаардлагатай мэргэжлийн, хууль зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. Үүнд:

№	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	<p>Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын суурь бүтцийн ажил гүйцэтгэх гэрээ, төслийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээ, үнэт цаас худалдан авах гэрээ, санхүүжилтийн гэрээ болон бусад гэрээ хэлцэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад салбарын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлцэл, конвенц, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэртэй нийцэж буй эсэх, эрх зүйн чадамжийн хүрээнд эрх үүргийн тэнцвэрт байдлыг хангасан эсэхэд дүгнэлт өгөх;</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн бүтээн байгуулалтын стратегийн ач холбогдол бүтээн байгуулалтын ашигт малтмалын ордыг ашиглаадаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор заасан. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа. Мөн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь тесөлсон үр дүнгээ өгөөгүй байна.</p>	<p>Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн сэдвээр хийж буй гүйцэтгэлийн аудитаар төсөлд оролцогч буюу хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч, захиалагчийн гэрээний хэрэгжилт, талуудын төсөлд зарцуулсан хөрөнгө, тэдгээрийн зарцуулалт, үр нөлөөг няялан шалгаж, төслийг хэрэгжүүлсэн эрх зүйн орчин, ажил гүйцэтгэх болон санхүүжүүлэх гэрээ, бусад дагалдан гарсан шийдвэр, гэрээ, хэлцэл, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг судлан Монгол Улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичигт нийцэж буй эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилт оршино.</p> <p>Холбогдох байгууллагаар хянаж баталсан зураг төслийн дагуу хүчин төгөлдөр мөрдэж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиож, магадлалаар баталгаажуулсан эсэх;</p> <p>Тус төмөр замын төслийн санхүүжилт нь хууль эрх зүйд нийцсэн байх;</p> <p>Монголын төмөр зам ХК нь тус чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглах, эзэмших хууль, эрх зүйн чадамжтай, эрх зүйн орчин бүрдсэн эсэх;</p> <p>Төслийг бүрэн чадлаар нь ашиглах боломжтой эсэх</p>	<p>Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газраас гаргасан шийдвэрүүд болон бусад эрх зүйн баримт бичгүүд нь Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх;</p> <p>Төслийг хэрэгжүүлэгчид буюу гүйцэтгэгч, захиалагч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий чадамжтай байгууллага байх;</p> <p>Холбогдох байгууллагаар хянаж баталсан зураг төслийн дагуу хүчин төгөлдөр мөрдэж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиож, магадлалаар баталгаажуулсан эсэх;</p> <p>Тус төмөр замын төслийн санхүүжилт нь хууль эрх зүйд нийцсэн байх;</p> <p>Монголын төмөр зам ХК нь тус чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглах, эзэмших хууль, эрх зүйн чадамжтай, эрх зүйн орчин бүрдсэн эсэх;</p> <p>Төслийг бүрэн чадлаар нь ашиглах боломжтой эсэх</p>
2	<p>Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн эсэх, бүтээн байгуулалтын ажлын явцад хууль, тогтоомжид орсон өөрчлөлтүүд нь бусад хууль тогтоомжид нийцсэн эсэх;</p>	<p>Төмөр замын тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тоогоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", БХБС-ын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм", бусад норм ба дүрэм, стандартууд</p>	<p>Төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх;</p> <p>Төмөр замын томоохон бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах чадамжтай эсэх;</p> <p>Төмөр замын трассын дагуух суурь бүтцийн хиймэл төхөөрөмж, далан, өртөө зөрлөгийн барилга байгууламж, төмөр замын дээд бүтэц, өртөөний замын дээд бүтэц, дохиолол холбоо, цахилгаан хангамжийн үе шатны ажил бүрд захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулсан эсэх;</p> <p>Төмөр замын төслийн</p>	<p>Төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх;</p> <p>Төмөр замын томоохон бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах чадамжтай эсэх;</p> <p>Төмөр замын трассын дагуух суурь бүтцийн хиймэл төхөөрөмж, далан, өртөө зөрлөгийн барилга байгууламж, төмөр замын дээд бүтэц, өртөөний замын дээд бүтэц, дохиолол холбоо, цахилгаан хангамжийн үе шатны ажил бүрд захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулсан эсэх;</p> <p>Төмөр замын төслийн</p>

				зарим ажилд гүйцэтгэгчээр ажилласан УБТЗ ХХК нь захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлж, захиалагчийн хяналтын зардал авч төслийн нэгжийн үйл ажиллагааг санхүүжүүлсэн нь хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх.			
3	Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийг бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцуулах эрх, зүйн орчин бурдсэн эсэх, засаж сайжруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт, санал боловсруулах;	Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Аж ахуйн нэгжийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нэмүү өртгийн албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцож, ашгийн төлөө ажиллаж байгаа нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хуулийн зорилт, агуулга зарчимтай нийцэж байгаа эсэх;	Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцсоноор бие бурэлдэхүүнийг нийгмийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, тайлагнах, зарцуулах эрх зүйн үндсийг тодорхойлсон, эрх зүйн орчин бурдүүлж чадсан эсэх;			
				Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцож, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, ашгийн тайлан тэнцэл гаргаж, баталгаажуулахгүйгээр зэвсэгт хүчний хөгжлийн санд орлого бурдүүлж байгаа нь татварын үйл ажиллагаанд баримтладаг зарчимуудтай нийцэж байгаа эсэх;	Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцож, гэрээгээр нэмүү өртөг шингэсэн ажил гүйцэтгэж, нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, буцаан олгох, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа эсэх;	Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцохдоо Улсын төсөвт үйлдвэрийн газар гэх улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авч үйл ажиллагаа явуулж байгаа нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх;	Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд бүтээн

				байгуулалтын үйл ажиллагаанд оролцохдоо уг төслийн санхүүжилтээс техник хэргэсэл буюу хөрөнгө бэлтгэсэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх;
				Олон улсын практикт Улсын батлан хамгаалах Зэвсэгт хүчнийг ашгийн төлөө үйл ажиллагаанд оролцуулдаг эсэх;
Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажил, үүргийн хүрээнд нэмэлт ажил хийх тохиолдолд гүйцэтгэх, ажил үүрэг бүрд нэмэлт ажил оруулах боломжтой.				Зэвсэгт хүчний орлого, зарлагыг хянадаг тогтолцоотой эсэх;
4 Гүйцэтгэх нийт ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээ, засаж сайжруулах талаар тодорхой дүгнэлт гаргах.				

## ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Хууль, эрх зүйн шинжээч нь ажлын даалгаварт тусгасан зорилгыг хэрэгжүүлж, ажил үүргийн хуваарийн дагуу дээрх ажилбаруудыг Аудитын олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журам, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид нийцүүлэн үндэслэл бүхий дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Төмөр замын төслийн хүрээнд хийгдсэн бүхий л гэрээ хэлцэл, хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээл, хөрөнгийн төвлөрүүлэлт, ашиглалт, удирдлага, дэд бүтэц, бүтээн байгуулалт, худалдан авах үйл ажиллагаа нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байж улс, үндэсний эрх ашигт нийцсэн зорилго, зорилтыг дэмжих, хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх нь нотолгоонд суурилж үнэлэгдэнэ.

Аудитын үр дүнд тулгуурлан дээрх 2 төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, түүний үр нөлөөний талаарх дүнг бодитой үнэлж, аудитын дүгнэлт, тайлан гарган холбогдох байгууллага, олон нийтэд үнэн зөв мэдээлнэ.

## ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хууль, эрх зүйн шинжээч нь олон улсын гэрээ, хэлцэл, төрийн бодлого, санхүүгийн менежмент, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, дүн шинжилгээ хийх, үнэлэх чадвартай, тухайн салбарын талаар мэдлэг, дадлага, туршлагатай холбогдох эрх бүхий иргэн, хуулийн этгээд (түншлэлээр оролцож болно) байна.

Хууль, эрх зүйн шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Хууль, эрх зүйн шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэг хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Хууль, эрх зүйн шинжээч нь дараах мэргэжил, мэргэшлийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Багаар ажиллах чадвартай, олон улсын гэрээ, хэлцэлд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;

- Хууль, эрх зүйн бакалавр, магистр түүнээс дээш боловсрол эзэмшсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй;
- Монгол Улсын Олон Улсын гэрээний эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, төслийн техник эдийн засгийн үндэслэл, санхүүжилт, хөрөнгө оруулалт болон Засгийн газар хоорондын, олон улсын гэрээнд дүгнэлт гаргахад зөвлөх, шинжээчээр ажиллаж байсан давуу талтай;
- Хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, шаардлагад нийцүүлэн судалгаа шинжилгээ хийж байсан, хууль зүйн магадлан шинжилгээ хийх, тайлан бэлтгэх, хууль зүйн дүгнэлт гаргах чадвартай;
- Хууль, эрх зүйн мэргэжлээр 5-аас дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;
- Хууль зүйн чиглэлээр олон улсын туршлагатай, судалгаа хийж байсан, Үндэсний аудитын газарт шинжээчээр ажиллаж байсан бол давуу тал болно. Монгол Улсад хэрэгжсэн бизнесийн том төслийн, хөрөнгө оруулалтууд, эздэрээтэй маргаанууд, хууль эрх зүйн өөрчлөлтүүдэд оролцож байсан зэрэг бусад туршлагууд.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажлын даалгаварт тусгагдсан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол, санал, тайлбар, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг цаг хугацаанд нь үнэн зөв чанартай хийх үндсэн шаардлагыг хангасан байна.

### **Бүрдүүлэх материал:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугуйлсан байх);

Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

### **ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дунг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

### **ДОЛОО. БУСАД**

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитын баг, бүрэлдэхүүнтэй хамтран ажиллаж, мэргэжлийн туслалцаа дэмжлэг, зөвлөгөө өгнө. Гэрээнд заасан ажилд шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт туссан ажлыг эхлүүлэх болон гүйцэтгэх явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Хууль, эрх зүйн шинжээч нь дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

